

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХӨГНӨ-ТАРНЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГАА 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2025/003/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Д.Даариймаа Утас: 70342495 Цахим хаяг: daariimaado@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

Анх. д. 02 № 20

танай _____ ны № _____ т

**ХӨГНӨ-ТАРНЫН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА
ДАРГА Б.ГОНЧИГ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 47.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 77.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

006020063

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд ТӨБЗГ-ын 792 тогтоолоор анхны өртөгөө элэгдлээрээ нөхсөн боловч ашиглах боломжтой 27 нэр төрлийн 64.3 сая төгрөгийн хөрөнгийн хугацааг сунгаж 11.6 сая төгрөгөөр үнэлсэн байна

Бусад асуудлын хэсэг

Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 2 зорилт 25 арга хэмжээний хэрэгжилт 83.2 хувиар дүгнэсэн, хөтөлбөр арга хэмжээнд зориулан 771.8 сая төгрөгийг төсөв батлагдаж, гүйцэтгэлээр хувийг зарцуулсан байна.

Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Ж.ЭНХЦОДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлт

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	37,289,902.00	43,773,251.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	593,876,478.91	616,192,733.22
	Нийт хөрөнгийн дүн	631,166,380.91	659,965,984.22
	Нийт өр төлбөрийн дүн	0	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	631,166,380.91	659,965,984.22
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	631,166,380.91	659,965,984.22
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	494,253,270.00	842,686,530.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	589,082,036.55	825,516,926.69
	Үйл ажиллагааны үр дүн	(94,828,766.55)	17,169,603.31
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(94,828,766.55)	17,169,603.31
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		631,166,380.910
	Тайлант оны үр дүн		17,169,603.31
	Эцсийн үлдэгдэл		659,965,984.22
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	494,253,270.00	841,073,180.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	490,926,331.75	801,463,822.00
	Үйл ажиллагааны ЦМГ	3,326,938.25	39,609,358.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(1,074,000.00)	(39,609,358.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	3,326,938.25	39,609,358.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	3,326,938.25	39,609,358.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		699,773,005.46
	Урсгал зардал		713,191,723.46
	Хөрөнгийн зардал		0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		243,000.00
	Улсын төсвөөс санхүүжих		43,400.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	52,269,194.00

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөгнө Тарнын БЦГ-ын хамгаалалтын захиргааны үндсэн зорилго, зорилтыг хангах, тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгалийн баялгийн хамгаалалт, ашиглалтын зохистой харьцааг тогтоох, байгаль хамгаалахад нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах, урьдчилан сэргийлэх, байгалийн унаган төрх, түүх соёлын дурсгалыг хамгаалах, аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэхийн зэрэгцээ амьтан ургамлын төрөл зүйлийг хамгаалах, өсөж үржих таатай нөхцөлийг бий болгох, бэлчээрийг зохистой хуваарьтай ашиглах, байгаль хамгаалахад олон нийтийн оролцоог хангахад чиглэнэ.

Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлууд

Хөгнө-Тарна БЦГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Хөгнө-Тарна БЦГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,799.6 мянган төгрөгөөр буюу 4 хувиар өссөн байна.

Тав. Аудитын гол асуудал

Хөгнө-Тарна БЦГ нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 546.9 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 785.5 мянган төгрөгөөр буюу 238.6 мянган төгрөгөөр өсгөн баталжээ.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 785.5 мянган төгрөгийг улсын төсвөөс олгож, гүйцэтгэлээр 713.2 мянган төгрөг буюу төсвийн 91 хувь зарцуулж 72.3 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулиар цахим хуудсанд мэдээлэхээр заасан мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 гүйлгээний 58,045.7, зарлагын 20 гүйлгээний 220,694.2 мянган мэдээллийг байршуулаагүй, мөн өмч хөрөнгөтэй холбоотой 18 тушаал шийдвэр мэдээлсэн байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

Найм. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 891,326.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс 2,100.0 мянган төгрөгийн 2 Төлбөрийн акт, 889,226.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

8.1. Төлбөрийн акт

1. Тайлант онд шатахууны зардлаас анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан 1,600.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2. Цалингийн зардлаас 500.0 мянган төгрөгийг 1 албан хаагчид шилдэг ажилтнаар тодорхойлж шагнасан зөрчил байна.

8.2 Албан шаардлага Байхгүй

8.3 Зөвлөмж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:1 Тайлант онд өөрийн орлогыг 5,280.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч орлогын бодит гүйцэтгэл 47,595.7 мянган төгрөгийг төвлөрүүлж 42,315.7 мянган төгрөгийн орлого давж биелсэн давсан орлогын 60 хувийг албан хаагчдын тэтгэмж, урамшуулалд 25,389.4 мянган төгрөгийг зарцуулсан нь орлогыг бодит төлөвлөхгүйгээс жил бүр давсан орлогоос урамшуулал авах шалтгаан болж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг, 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогыг өмнөх оны гүйцэтгэл болон төлбөр хураамжийн журамтай уялдуулан төлөвлөдөг байх.

Илрүүлэлт:2 Хөрөнгийн тооллогыг хийж дууссаны дараа ТӨБЗГ-аас хөрөнгө актлах тушаал ирж хөрөнгийг актлан, үнийг шинэчлэн тогтоож ажилласан ч тооллогын бодит дүн өөрчлөлтийг тусгаагүй байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т “Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-ын шийдвэрээр хөрөнгийг актлах, үнийг шинэчлэн тогтоосны дараах хөрөнгийн үлдэгдлийг дахин тоолж үлдэгдлийг баталгаажуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дүгээр сарын 25-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн

Өөрийн орлогыг бодит төлөвлөөгүйгээс жил бүр давсан орлогын 60 хувьд урамшуулал олгож байна.	1	42,315.7					1	42,315.7				
ТӨБЗГ-ын шийдвэрээр хөрөнгийг актлах, үнийг шинэчлэн тогтоосны дараах хөрөнгийн үлдэгдлийг дахин тоолж үлдэгдлийг баталгаажуула агүй.	1	846,910.4					1	846,910.4				
Тайлант онд шатахууны зардлаас анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан 1,600.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	1,600.0	1	1,600.0								
Цалингийн зардлаас 500.0 мянган төгрөгийг 1 албан хаагчид шилдэг ажилтнаар тодорхойлж шагнасан зөрчил байна	1	500.0	1	500.0								
Дүн	4	891,326.1	2	2,100.0			2	889,226.1				